

## ГЕРМАН-МОНГОЛ, МОНГОЛ-ГЕРМАН ОРЧУУЛГЫН БҮТЭЭЛИЙН ТОЙМ

Ж.Ариун<sup>3</sup>

**Товч утга:** 1930-аад онд их зохиолч Д.Нацагдорж “Алтан цох” зохиолыг орчуулснаар герман-монгол орчуулгын бүтээл төрсөн хэмээн баримталдаг байна. Социализмын үед буюу 1990-ээд оны ардчилсан хувьсгал өрнөх үе хүртэл орчуулсан зохиолын дийлэнх нь агуулгын хувьд үзэл сурталжссан байх тул БНАГУ-ын (хуучны социалист герман улс) зохиолчдын бүтээл туурвил байдаг байна. Орчин цагт энэ хандлага нэгэнт үгүй болж нийгэм улс төрийн, шинжлэх ухаан техникийн, үүнд, сэтгэлгээний, гүн ухааны гэх мэт өргөжин тэлж байна. Монгол-герман орчуулгын хувьд Erich Haenisch, Bernhard Julg, Walther Heissig, Erika Taube, Manfred Taube, Klaus Koppe, Barkmann, Udo.B., Renate Baiwe зэрэг судлаачид сонгодог болон орчин цагийн зохиол бүтээл, үлгэр туульсыг орчуулсан байна. Тооны хувьд авч үзвэл сүүлийн жилүүдэд өмнөх цаг үетэй харьцуулахад герман хэлнээс эх хэлнээ орчуулсан бүтээлийн тоо төдийлэн хангалттай бус байгаад их, дээд сургуулиуд, үүнд, МУИС мөн өөрийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт шинэчлэл хийн тусгах шаардлага бий.

**Түлхүүр үг:** Герман-монгол орчуулгын бүтээлийн төрөл, он дараалал, зарим нэгэн ажиглалт, монгол-герман орчуулгын зохиолын жагсаалт

Хүн төрөлхтний соёл нь хэдийвээр улс үндэстэн, ард түмнүүдийн бие даасан өв сан мөн боловч эцсийн дүндээ нэгдмэл цул шинжтэй үзэгдэл юм. Аль ч ард түмний урлаг уран зохиол нь харилцан бүтээлчээр суралцаж, шинэ шинэ агуулга, хэлбэр, дүр, үзэл санаа, туурвилзүйн арга барил, хэл найруулгын уран чадвар, өвөрмөц онцлогуудаар нэмэн баяжиж төгөлдөржиж байдаг жамтай гэхийн сацуу *менталитет гэж юу вэ?* гэсэн асуулт давхар урган гарч ирнэ. Энэ нь *үндэстний онцлог, оюун санаа, сэтгэлгээний хэв маяг* гэсэн үг ажээ.

Олон соёлын харилцаанд өөр хоорондоо хүндэтгэлтэй оршин тогтнож хөгжихөд менталитетийн ялгааг ойлгох, ойлгуулахад орчуулагч, орчуулгын бүтээлийн үнэ цэнэ давхар орших нь гарцаагүй хэмээгээд 1930-аад онд их зохиолч Д.Нацагдоржийн орчуулсан “Алтан цох” зохиолыг герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан анхны зохиол хэмээснийг баримталбал цөөнгүй тооны бүтээл байх боломжтой болов уу. Орчуулгын төрөл зүйлээр нь авч үзвэл, нийгэм улс төрийн зохиол бүтээл, шинжлэхуаан-техникийн зохиол бүтээл, уран зохиолын орчуулгын бүтээл, үүнээс үргэлжилсэн үгийн зохиолын, яруу найргийн, жүжгийн зохиолын, хүүхдийн уран зохиолын бүтээл тус тус байна. Сүүлийн үед герман киног орчуулан үзэгчдэд хүргэж байгаа ч энэ удаагийн

<sup>3</sup>МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхимийн багш, доктор /Ph.D/

судалгаанд тусгаагүй болно. Орчуулгын бүтээлийг найруулгын төрөл зүйлээр нь багцлан тоймлон харуулбал,

Нийгэм-улс төрийн зохиол бүтээлээс Карл Маркс “*Капитал, I боть*”, “*Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь*”, орч. Б.Бирваа, ред. Х.Лхамдорж, Д.Чойжил, А.Бямбаноров, УБ, 1999 (938 хуудас бүхий), Карл Маркс “*Капитал, III боть*”, “*Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь*”, *III дэвтэр*, “*Капиталист үйлдвэрлэлийн нийт процесс*”, орчуулагч Б.Бирваа, УБ, 2001 (524 хуудас бүхий), Очирбат Пунсалмаагийн, “*Тэнгэрийн цаг*”, 1996, орчуулсан У.Эрдэнэсанаа, Конрад-Аденауэрийн Сан, 2013, Эрих Фромм, “*Бий эсвэл Байх*”, орчуулагч С.Молор-Эрдэнэ, УБ, 2010, Мартин Хайдеггер, “*Байх ба Хугацаа*”, орчуулагч С.Молор-Эрдэнэ, УБ, 2011, “*Би хэн бэ?*” орчуулагч С.Молор-Эрдэнэ<sup>4</sup> зэргийг дурдаж болно.

“Бүрэнгийн Бирваа нь “Капитал”-ыг орчуулсан нь Монголын эдийн засгийн сэтгэлгээний хөгжилд төдийгүй нийгэм-улс төрийн зохиолын орчуулгын түүхэнд цоо шинэ хуудас нээсэн юм” хэмээн МУСГЗ, сэтгүүлч Жа.Пүрэв “Монголын нэрт орчуулагчид” номд<sup>5</sup> дурдсан байна.

С.Молор-Эрдэнэ нь философийн шинжлэх ухаанаар ХБНГУ-д докторын зэрэг хамгаалсан эрдэмтдийн нэг бөгөөд өрнийн сонгодог суут гүн ухаантнуудын бүтээлд үндэслэн сэтгэлгээний шинэ хэв маягийг оруулж ирэхийг зорин ажиллаж буй судлаач болно.

Шинжлэх ухаан-техникийн зохиол бүтээлийн тухайд Ханнс-Зайделийн сан, Конрад Аденауэрийн сан, “*Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ёс зүйн үндэс*” симпозиумын эмхэтгэл, Интерпресс, 1998 (2 хэлээр, 151 хуудас), Баркманн.У.Б, Хайсандай.Л, “*Монгол –Германы харилцаа, Өнгөрсөн үе – Эдүгээ-Хэтийн төлөв*”, МУ, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтсоны 30 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материалын эмхэтгэл, Монголын ШУА, ОУСХ, Монголын “Герман судлал” Төв, УБ, 2004 (2 хэлээр, 354 хуудас), Ханнс-Зайделийн сан, ГТХАН (GTZ), “*Үндсэн хууль ба ардчилсан эрхзүйт төр*” бага хурлын баримт материалын эмхтгэл, УБ, 2004 (429 хуудас), Конрад Аденауэрийн сан, Монгол-Германы чуулган, “*Иж бүрэн түншлэлийн төлөө*”, Конрад Аденауэрийн сан, Монгол-Германы чуулган хамтран зохион байгуулсан бага хурлуудын баримт материалын эмхтгэл, УБ, 2004 (2 хэлээр, 398 хуудас), Монгол-Германы гүүр ТББ, “*МУ-ын эдийн засгийн хөгжилд Германд төгсөгчдийн оруулж буй хувь нэмэр*”, Монгол-Германы гүүр ТББ, АГЕФ Берлин хамтран зохион байгуулсан Германд төгсөгчдийн 3-р өдрүүдийн баримт материалын эмхтгэл, Ган Принт, 2006 (116 хуудас), Баркманн У.Б, Саруул.А, Алтай.Г, “*Чингис хаан хийгээд түүний өв*”, ХБНГУ-ын Урлаг, Үзэсгэлэнгийн Их Танхимд гаргасан “Чингис

<sup>4</sup>[https://mn.wikipedia.org/wiki/Санжаадоржийн\\_Молор-Эрдэнэ](https://mn.wikipedia.org/wiki/Санжаадоржийн_Молор-Эрдэнэ)

<sup>5</sup>Монголын нэрт орчуулагчид, 28-р тал, Мөнхтэнгэр дэлхийн эв нэгдлийн холбоо, УБ, 2005 он

хаан хийгээд түүний өв – Монголчуудын дэлхийн гүрэн” Бонн 2005.6.16 – 9.25 үзэсгэлэнд зориулж ДААД болон DFG-ээс зохион байгуулж хийлгэсэн бага хурлуудын материал, ДААД болон Германы Судалгааны нийгэмлэг, Монгол Судлалын Төв, МУИС, УБ, 2007 (2 хэлээр, 383 хуудас), БаркманнУдо Б., “Монгол-Германы харилцаа-Өнөөгийн байдал ба хэтийн төлөв” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд, УБ, 2013 (2 хэлээр, 306 хуудас), Исаак Якоб Шмидт, “Монгол хэлний хэлзүй” (орчуулгын зохиол), УБ, 13х.х, орчуулсан Г.Лувсан, Ж.Ариун, М.Одонтуяа, Ц.Доржнямбуу, Г.Эрдэнэ-Наран, Ч.Сэлэнгэмөрөн гэх мэт нэрлэж болно.

Эдгээр эмхэтгэлд монголын хийгээд германы нэр хүнд бүхий монголсудлаачид, тухайлбал, К.Загастер, Х.Г.Хюттель, М.Вайерс, У.Б.Баркманн, Ш.Чоймаа, С.Дулам, Ж.Болдбаатар, Ж.Чимиддорж (Өвөр Монголын Их Сургууль, Хөх Хот, БНХАУ), орчин цагийн эрхзүйчдийн гол төлөөлөл болох Б.Чимид, Г.Совд, Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа, С.Жанцан, улс төрийн хүчний төлөөллүүд, үүнд, П.Очирбат, Н.Багабанди, С.Батболд, Д.Лүндээжанцан, Б.Батбаяр (Баабар), М.Энхсайхан, Л.Гүндалай, Л.Болд төдийгүй ХБНГУ-ын төрийн дээд албан тушаалтнуудын судалгаа, илтгэл, баяр хүргэж хэлсэн үгс багтаж байна.

Монгол судлаач Удо Баркманн нь МУИС-ын төгсөгч бөгөөд германчууд дундаа өөрчлөлт шинэчлэлийн үеийн “Mongolei-Experte” буюу “монголоор дагнасан судлаач” хэмээн цоллуулдаг олон жилийн туршлага хуримтлуулсан арвин бүтээлтэй эрдэмтэн тул герман хэлний орчуулагч, судлаач бэлтгэн гаргах үйлст хувь нэмэр нь гарцаагүй өндрөөр үнэлэгдэж таарна.

Уран зохиолын орчуулгын талаар герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан анхны уран зохиолын орчуулгыг их зохиолч Д.Нацагдоржийн орчуулсан “Алтан цох” зохиол хэмээн зарим судлаачид үздэг бөгөөд МУИС-ийн багш Г.Эрдэнэнаран 2009 онд хийсэн бүтээлийн судалгаандаа мөн он хүртэл герман хэлнээс монгол хэлрүү орчуулсан нийт 70 орчим бүтээл байгааг, мөн эдгээр орчуулгын зохиолыг герман хэлнээс шууд буюу орос хэлнээс дам орчуулсан байнагээд герман хэлнээс шууд орчуулгыг Д.Нацагдорж, Д.Гонгор, Г.Сосор, Д.Хандмаа, Ч.Галсан, Д.Алтанхуяг, Д.Наваан-Юндэн нарын орчуулагч, зохиолчид хийсэн байна<sup>6</sup>” хэмээжээ. Багш Г.Эрдэнэнаран 2007 он хүртэл хийсэн орчуулгийг үндсэн гурван төрлөөр ангилжээ. Харин энэхүү судалгааны хүрээнд орчуулгын бүтээлийг *үргэлжилсэн үгийн, яруу найргийн, жүжгийн, хүүхдийн уран зохиолын* хэмээн шинээр ангилан түүвэрлэж, тухайн орчуулгын бүтээл хэвлэгдэн гарсан он дарааллын дагуу жагсаан оруулав.

Үргэлжилсэн үгийн зохиолоос 1964 он Петцольд.Ц.И., “Агуу их бүтээл”, орчуулсан Д.Гонгор, редактор Ц.Энэбиш, Хардер.Г., “Нугат хөндийн айлд”,

<sup>6</sup>Герман уран зохиолыг монгол хэл рүү орчуулах уламжлалаас, эрдэм шинжилгээний илтгэл, МУИС, ГХСС, Багш нарын ЭШБХ, УБ, 2007 он

орчуулсан Д.Гонгор, редактор Ш.Очирбат, 1967 он Нойч.Э, “Чулуун мөр”, орчуулсан Д.Гонгор, редактор Ц.Шүгэр, 1968 он Келлерманн.Б, “Далд зам”, орчуулсан Г.Сосор, редактор Ц.Шарав, 1970 он Нойманн К., “Гезине охин”, орчуулсан Д.Хандмаа, 1972 он, Апитц Б., “Араатны дунд гар хоосон”, орчуулсан Д.Хандмаа, редактор Г.Лувсан, Тухольский К., “Бүү хүлээ”, орчуулсан Ч.Галсан, редактор Д.Алтанхуяг, 1974, Петерсен Я., “Урхи”, орчуулсан Х.Гомбо, Улаан-Од, 1974 оны 11 сарын 2, дугаар 88, Манн Х., “Боол”, орчуулсан Г.Сосор, Ч.Галсан, редактор Г.Лувсан, 1976 он, Зегерс А., “Долоо дахь загалмай”, орчуулсан Д.Хандмаа, редактор Д.Алтанхуяг, 1978 он “Үнэн үнэнээрээ л байх сайхан” (шог өгүүллэг), орчуулсан Ч.Галсан, “Хөдөлмөр”, №46, 1979 он, Зегерс А., “Зэгсэн гуурс” (өгүүллэг), орчуулсан Д.Алтанхуяг, “Цог”, №6, 141-150 тал, Тёрнеквист Г. “Манаач”(шог өгүүллэг), орчуулсан Д.Гонгор, “Хөдөлмөр”, №130, Хардер Г., “Аавтайгаа уулзах хориотой”, орчуулсан А.Цэрэнчулуун, редактор Н.Наваан-Юндэн, Финкер Курт, “1944 оны 7-р сарын 20-ны хуйвалдаан”, орчуулсан Д.Хандмаа, редактор Д.Алтанхуяг, 1980 он, Вийнер Р., “Хотын зах дахь бяцхан байшин”, орчуулсан А.Алтанхуяг, “Тоншуул”, №12, 1982 он, Вельм А., “Пуговица буюу түлхүүртэй мөнгөн цаг”, орчуулсан Ц.Шарав, редактор Д.Алтанхуяг, УБ, СнХК, 1983 он, Ганс Арнольд, “Бараагаа сурталчилсан нь”, орчуулсан Х.Мэргэн “Цог” №1, 86-ртал, Леонхард Р., “Хот, дуу хоолой хоёр”, орчуулсан Д.Алтанхуяг, “Утгазохиол, урлаг” №17, 1988 он, Хермлин С., “Үдшийн гэгээ”, орчуулсан Ч.Галсан<sup>7</sup>, Ш.Цогт, Кестнер Э., “Эрхийн чинээ эр”, орчуулсан Д.Хандмаа, редактор Ц.Сүхбаатар, 2002 он, Теодор Эрнст, Амадеус Хоффманн “Самар цөмүүр ба хулганы хаан” орчуулсан Д.Хандмаа, редактор Д.Алтанхуяг, 2009 он, Штефан Цвайг, “Танихгүй эмэгтэйн захидал”, 2010 он, Н.Лувсандорж, “Geschichten – Үгүүллэгүүд” (2 хэлээр) байхын сацуу 2013 онд бакалаврын төгсөлтийн ажлын хүрээнд МУИС-ийг Герман судлалаар төгсөгч Ц.Мөнхбуянт Гётегийн “Залуу Вертерийн шаналан” романыг орчуулжээ.

Н.Лувсандоржийн “Үгүүллэгүүд” эмхэтгэлийн тухайд “Хэрвээ уран зохиолыг бусдын соёлыг харах цонх хэмээвээс энэхүү түүвэр онцгой юм. ...цаг хугацааны хувьд 200 гаруй жил, сэдвийн хувьд маш өргөн хүрээг хамарч байна. Герман зохиолын хэсэг соён гэгээрүүлэлтийн болоод сонгодог үе (18-р зуунаас 19-р зууны эхэн)-ийн ёгт үлгэр, үгүүллэгээр эхэлж улс төрийн эргэлт ба дахин нэгдсэн 1990 оноос хойших үеийн бүтээлүүдээр төгсөж байна. Монголын үгүүлэхүйн урлагийн төлөөлөл болгож Д.Нацагдорж, С.Эрдэнэ, Л.Түдэв нарын бүтээлийг Ч.Галсангийн орчуулгаар оруулжээ. Чинагийн Галсан бас энэхүү төлөөлөлд орж байна” хэмээн ГЭСА-ны дэмжлэгээр хэвлэгдсэн хоёр дахь түүврийн өмнөх үгийг тэрлэгч Детлеф Гертнер өгүүлжээ<sup>8</sup>. Эмхэтгэлд *Готтхолд Ефраим Лессингийн 5, Йоханн Вольфганг фон Гётегийн 1, Йоханн Петер Хебелын 2, Хайнрих фон Клайстын 1, Роберт Валзерын 1, Альфред Дёблиний 1,*

<sup>7</sup> Geschichten-Үгүүллэгүүд, 6-р тал, БИТ ПРЕСС ХХК, 2010 он

<sup>8</sup> Gedichte-Шүлгүүд, 5-р тал, БИТ ПРЕСС ХХК, 2009 он

Франц Кафкагийн 2, Вольфганг Хилдесхаймерын 1, Ервин Штриттматтерын 1, Хайнрих Бөллийн 1, Дийтер Хилдебрандтын 1, Эрих Көөлерын 1, Ирмтрауд Моргнерын 1, Хеннинг Фенскегийн 1, Моника Зек-Агтегийн 1 өгүүллэг, тэрчлэн, Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс”, С.Эрдэнэ “Малын хөлийн тоос”, Л.Түдэв “Багтай танилцсан минь”, Ч.Галсан “Die Tiwa sagen”, “Тетро” өгүүллэгүүд багтсан байна.

Яруу найргийн бүтээлд Д.Алтанхуягийн орчуулсан Кирш Райнер “Лилиягийн домог”, “Чи бид”, Утга зохиол урлаг, 1974 оны 9 сарын 27, дугаар 40, Хайне Х., “Герман орон (Өвлийн нэгэн үлгэр)”, редактор Б.Бирваа, УБ., УХК, 1978, 79-р тал, Шайбнер.Э., “Малчны хүү буюу тэмээ унах нь”, “Утга зохиол урлаг”, 1980 оны 9 сарын 9, №37, Георг Маурер, “Амраг минь чи жаахан хүлээ!”, “Утга зохиол, урлаг” 1981 оны 4-р сарын 17, №16, Нето А., “Шүлгүүд”, редактор Б.Пүрэвбаатар, Ева Штриттматер, “Чамдаа”, “Утгазохиол, урлаг” 1982, 10-р сарын 8, №41, Бартш К., “Яруу найраг”, “Утга зохиол, урлаг”, 1983 оны 4 сарын 22, №17, Трампе В., “Өршөөл гуйхгүй”, “Утгазохиол, урлаг”, 1983 оны 4-р сарын 22, №17, Фуйман Ф., “Нибелунгуудын тухай дуулал”, редактор З.Түмэнжаргал, УБ, СнХК, 1983, 134-р тал, Курт Барч, “Төрд падгүй нэгэн хүнд зориулсан оршлын бичээс”, “Утга зохиол, урлаг”, 1984 оны 10-р сарын 5, №41, Курт Барч, “Үүд”, “Утга зохиол, урлаг” 1984 оны 10-р сарын 5, №41 болно. 2009 онд Н.Лувсандорж “*Gedichte-Шүлгүүд*” хэмээх бүтээлийг дуун хөрвүүлж, эмхэтгэсэн нь герман хэл суралцагсдад чамгүй үнэтэй гарын авлага болсон нь дамжиггүй. Намжилдоржийн Лувсандоржын “Шүлгүүд” эмхэтгэлийн тухайд Н.Лувсандорж шүлгүүдийг шилж сонгон, нилээд хэсгийг орчуулсан байна. Тэрээр Ц.Дамдинсүрэн, Н.Наваан-Юндэн, С.Доржпалам, Б.Бааст, Б.Явуухулан, Д.Чимэддорж, Ц.Хасбаатар, М.Ширчинсүрэн, Г.Алтай, Ч.Галсан нар герман болон орос хэлнээс урьд өмнө орчуулж энд тэнд тарж тархсан болон хэвлэгдээд олдохгүй болсон шүлгүүдийг цуглуулан эмхэтгэжээ. Үүнээс гадна, огт нийтлэгдэж байгаагүй Шиллерийн “Амьдрал хэмээх жүжиг” (Ч.Мөнхөөгийн орчуулга) болон Ч.Галсангийн шүлгүүдийг (А.Цэрэнчулууны орчуулга) мөн хамруулан оруулжээ. Хөлдөрлиний зарим шүлгүүд Ч.Галсангийн орчуулгаар анх удаа нийтлэгдэж байгаад бид баяртай байна. Бас Д.Нацагдоржийн шүлгүүдээс Ч.Галсан, Г.Алтай, Н.Лувсандорж нар орчуулсан нь энд содон байна” хэмээн номын оршил хэсэгт уг бүтээл төрөхөд чамгүй хувь нэмрийг оруулсан тухайн үеийн ГЭСА-ны багш Детлеф Гэртнер тэмдэглэсэн байна. Уг бүтээлд Гётегийн 51 шүлэг, Шиллерийн 18 шүлэг, Хөлдөрлиний 10 шүлэг, Хайнегийн 43 шүлэг, Д.Нацагдоржийн 8 шүлэг, Ч. Галсангийн 6 шүлэг орчуулгын хамт багтжээ.

Жүжгийн зохиол бүтээлийн тухайд Монсудар хэвлэлийн газраас 2007 оноос эхлүүлэн дэлхийн сонгодог уран зохиол, шинэ үеийн уран зохиолуудаас

<sup>9</sup> Ариун Жадамбын, Герман-монгол хэлний байц гишүүн өгүүлбэртэй УНӨ-ийн зэрэгцүүлсэн судалгаа, дисс., 136-167 тал, УБ, 2004 он

сорчлон түүвэрлэж орчуулан хүргэх ажил амжилттай хэрэгжиж буйн хүрээнд 2009 онд “*Фауст*” жүжгийн зохиолын энэ удаагийн орчуулгын хувилбар гарсан байна. Энэхүү бүтээлийг герман хэлнээс С.Батбилиг орчуулсан байна. Йоханн Вольфганг фон Гёте энэхүү зохиолоо 1770 онд эхлүүлэн 1833 онд хэвлэлтэнд шилжүүлэн 60 жилийг зориулсан байна.

Хүүхдийн уран зохиолоос герман хэлнээс орчуулсан 1990-ээд оны өмнөх хүүхдийн зохиол, тэр дундаа үлгэрүүд ахин шинээр хэвлэгджээ. Эдгээрээс ах дүү Гриммийн болоод В.Гауфийн үлгэрүүд нилээдгүй багтсан байна.

Герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан Ах дүү Гриммийн “*Чөтгөр ба түүний эмээ*”, Рудольф Эрих Распэ “*Мянгуужингийн адал явдал*”, Отфрид Пройслер “*Бяцхан шулам*”, Фэликс Залтен “*Бэмби ба ойн амьдрал*” зэрэг бүтээлүүд нь сүүлийн жилүүдэд манай нэрт орчуулагчдын эмхэтгэн, орчуулж гаргасан “Хүүхдийн шилмэл зохиолын эрдэнэсийн сан 108 боть”-д багтжээ. Эдгээр бүтээлүүд нь австри, германы хүүхдийн сонгодог зохиолчдын туурвил бөгөөд тэдний энэхүү үнэт зохиолууд дэлхийн хүүхдийн уран зохиолын сонгодог бүтээлд багтдаг байна.

Сүүлийн үед герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан хүүхдийн зохиолуудыг авч үзвэл жилд дунджаар 1-2 зохиол хүүхдийн гар дээр очдог гэсэн албан бус статистик баримт байна.

Германы алдарт зохиолч Михайл Эндегийн “*Момо*” хэмээх хүүхдийн бүтээлийг герман хэлнээс монгол хэл рүү залуу орчуулагч Х.Хулан, Швейцарын утга зохиолын хамгийн шилдэг номоор шалгарсан, өнгөрсөн зууны дэлхийн хүүхдийн уран зохиолын хамгийн шилдэг 10 бүтээлийн тоонд зүй ёсоор орох Ж.Спайрийн “*Хэйди охин*”-ыг бүрэн эхээс нь монгол хэл рүү орчуулагч Г.Ариунцэцэг орчуулжээ. Үүний зэрэгцээ 1973 он “*Амтат будаа*” (*Герман ардын үлгэр*), орчуулагч Ч.Сэрээнэндорж, “*Тиль Ойленштийгелийн адал явдал*”, орчуулсан Ч.Галсан, “*Таван хуруу*” герман ардын үлгэр, орчуулсан Г.Ловор, “*Газар газрын үлгэр*”, 1974 он, Штриттматтер Э., “*Педро хэмээх одой азарга*”, орчуулсан Ч.Галсан, редактор Г.Лувсан, Эрих Кестнер, “*Эрхийн чинээ эр*”, орчуулсан Д.Хандмаа, редактор Ц.Сүхбаатар, 1976 он, Распе Э., “*Мянгуужинд тохиолдсон явдлууд*”, редактор Б.Мягмаржав, Теодор Эрнст, Амадеус Хоффманн, “*Самар цөмүүр ба хулганы хаан*”, орчуулагч Д.Хандмаа, редактор Д.Алтанхуяг, 2015 онд бакалаврын төгсөлтийн ажлын хүрээнд МУИС-ийн Герман судлалын ангийн суралцагч Ц.Энхмөрөн Эрих Кестнерийн “*Emil und die Detektive*” буюу “*Эмиль мөрдөгч болсон нь*” хүүхдийн романыг орчуулжээ.

Герман хэлнээ орчуулсан монгол зохиолын хувьд 2002 онд МУИС-ын 60 жилийн ой, Олон улсын монголч эрдэмтдийн VIII их хуралд зориулан МУ-ын гавьяат багш агсан, доктор Гэндэний Лувсан болон доктор С.Алимаа нарын хэвлүүлсэн “Германы монголч эрдэмтдийн товч намтар, бүтээлийн жагсаалт”-ыг нэрлүүштэй. 239 хуудас бүхий уг бүтээлд монгол судлалын талаар дагнан

мэргэжсэн 35 судлаач, эрдэмтдийн бүтээлийг цагаан толгойн дэсээр жагсаан харуулсан байна. Монгол-герман орчуулгын бүтээлийн орчин цагийн содон жишээ гэвэл Тавдугаар гэгээн ноён хутагт Данзанравжаагийн “Саран хөхөөний намтар” дуулалт жүжгийн орчуулга болох *Fünfte Noyan Khutukhtu Danzanrabjai, Das Leben des Mondkuckuck, aus dem Mongolischen Petra Szemacha, ZDM PRINTING in Ulaanbaatar, 2008 юм.* Бүтээлийг Лайпцигийн Их Сургуулийн доктор Petra Szemacha орчуулсан бөгөөд 2002-2003 онд МУИС-д монгол хэл судалж байсан бөгөөд түүний дипломын ажлын сэдэв нь “Тавдугаар Гэгээн ноён Хутагт Данзанравжаа. Саран Хөхөө. Шашины уламжлал хийгээд урлагийн бүтээлч сэтгэлгээ” ажээ. Монгол-герман орчуулгын бүтээлийг <https://de.wikipedia.org/wiki> сайтаас хайлт хийн хавсралтаар оруулав. (Хавсралт 1)

### Дүгнэлт

- Социализмын үед монгол хэлнээ орчуулсан зохиолуудын дийлэнх нь нийгэм- улс төрийн үзэл сурталжсан чиг хандлагатай байна. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш БНАГУ-ын зохиолчдын бүтээлийг нэн тэргүүнд сонгон орчуулдаг байжээ.
- Орчин цагийн орчуулгын бүтээл агуулгын хувьд баяжин, дан ганц уран зохиолын орчуулгаар үл хязгаарлагдан философи, түүх, соёл, эдийн засаг, эрхзүй зэрэг өргөн хүрээг хамрах болсон нь нэн сайшаалтай.
- Орчуулгын зохиолын арвин баримт герман-монгол, монгол-герман зэрэгцүүлсэн хэлзүйн судалгаанд эх хэрэглэхүүн болохын жишээ нь Бруно Апитцын зохиол, Д.Хандмаагийн орчуулга “*Араатны дунд гар хоосон*”, Хайнрих Манны зохиол, Г.Сосорын орчуулга “*Боол*” зохиолоос түүвэрлэн авсан 8 орчим хэвлэлийн хуудас ХНӨ болно.Тооны хувьд авч үзвэл сүүлийн жилүүдэд өмнөх цаг үетэй харьцуулахад герман хэлнээс эх хэлнээ орчуулсан бүтээлийн тоо төдийлэн хангалттай бус байгаад их, дээд сургуулиуд, үүнд, МУИС мөн өөрийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт шинэчлэл хийн тусгах хэрэгтэй болов уу. Үүнийг өгүүлэх нэгэн шалтгаан нь монгол соёл-иргэншлийн “*экзотик*” хэлбэр болон шахагдаж буй тува нарын нарийн нандин бүхнийг 30 гаруй бүтээлийн хүрээнд герман хэлээр туурвиж (1992 оноос эхлэн), герман хэлний үгийн санд ховор үгийн сувдан хэлхээг урлаж буй МУСГЗ, нэрт орчуулагч, зохиолч Чинагийн Галсангийн бүтээлийг(Хавсралт 2)эх сайхан монгол хэлнээ дуун хөрвүүлэх цаг үеийн шаардлага юм.

Хавсралт I

- Walther Heissig: *Geschichte der mongolischen Literatur*. (in zwei Bänden), Wiesbaden 1972.  
Diese grundlegende Literaturgeschichte des bedeutenden Mongolisten umfasst das 19. Jahrhundert und den Beginn des 20. Jahrhunderts und enthält auch Textproben der Dichter (u.a. von D. Rawdshaa), aus Epen und anderen anonymen Werken. – Daneben erschienen von W. Heissig zahlreiche, oftmals sehr spezielle Arbeiten zur alten mongolischen Literatur und zur Geistesgeschichte des zentralasiatischen Nomadenvolkes.
- Erika Taube: *Chrestomathie der mongolischen Literatur des 20. Jahrhunderts*. Leipzig 1972. Die Einleitung ist als Skizze der neuen mongolischen Literatur seit 1921 angelegt.
- Erika und Manfred Taube: *(Mongolische) Literatur*, in: *Schamanen und Rhapsoden*. Leipzig 1983. Zur Volksdichtung und zur schriftlichen mongolischen Literatur vor 1921.
- Renate Bauwe: *Nachwort zu: Erkundungen. 20 mongolische Erzählungen*. (Ost-) Berlin 1976.
- Renate Bauwe: *Mongolische Literatur*. In: *Bl-Lexikon Ostasiatische Literaturen*. Leipzig 1985. Mit 29 Personen-, Werk- und Sachartikeln.
- Renate Bauwe und Fritz Gruner: *Nationale Traditionen der Literatur und Probleme ihrer Verarbeitung bei der Schaffung einer sozialistischen Literatur in der Mongolei und in China*. In: *asien, afrika, lateinamerika*. (Ost-) Berlin, Heft 13 (1985)
- Renate Bauwe: *Auf der Suche nach neuen Werten. Mongolische Literatur in der Umorientierung*. In: *Mongolische Notizen. Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft e. V. (Bonn)*. Nr. 4/1995. Zur gesellschaftlich-literarischen Entwicklung nach 1990.
- In Kindlers neues Literaturlexikon in 20 Bänden (München 1988–1992) sowie den Ergänzungsbänden 21 und 22 (München 1988) wurden zahlreiche Artikel zu einzelnen Werken der mongolischen Literatur aufgenommen (Verfasser: W. Heissig und Renate Bauwe).
- Klaus Oehmichen: *Die mongolische Volksdichtung und ihr Einfluss auf die Entwicklung der modernen mongolischen Literatur*. In: *Weimarer Beiträge*. Heft 12/1984
- Klaus Oehmichen: *Daschdordshijn Nazagdordsh – Dichter des mongolischen Volkes*. In: *Neue deutsche literatur*. (Ost-) Berlin, Heft 6/1987. Über den Begründer der modernen mongolischen Literatur.
- Klaus Oehmichen: *Mongolische Dichtung*. In: *Ostragehege. Zeitschrift für Literatur, Kunst*. (Dresden), Nr. 42, Heft II/2006
- Klaus Oehmichen: *Gebrochene Biographien. Mongolische Autoren, die als Schüler,*



*Studenten und Praktikanten in Deutschland waren.* In: *Mongolische Notizen.* (Bonn), Nr. 15/2006.

Biographische Skizzen über fünf Autoren, u.a. D. Nazagdordsh und D. Namdag.

- Klaus Oehmichen: *Gedanken über fünf zentrale Gestalten der mongolischen Geschichte und Kultur.* In: *Mongolische Notizen.* (Bonn), Nr. 16/2007. Enthält u.a. eine biographische Skizze des Nationaldichters D. Rawdshaa.
- Klaus Oehmichen: *Zehn mongolische Dichter.* In: *Mongolische Notizen.* (Bonn), Nr. 17/2008. Biographische Skizzen weiterer bedeutender mongolischer Schriftsteller.
- Artikel zu mongolischen Autoren sowie anonymen Werken finden sich in allen einschlägigen DDR-Lexika zur Weltliteratur, die zwischen 1963 und 1988 erschienen sind.

*Neuere Veröffentlichungen aus der alten mongolischen Literatur in deutscher Sprache (Die angegebenen Autoren sind meist Herausgeber und Übersetzer zugleich.)*

- Walther Heissig: *Helden-, Höllenfahrts- und Schelmengeschichten der Mongolen.* Zürich 1962. Enthält u.a. Tschinggis-Chaan-Spruchdichtungen und Auszüge aus dem Geser-Chaan-Epos.
- Walther Heissig: *Mongolische Volksmärchen.* Düsseldorf/Köln 1963. Eine erste umfangreiche Ausgabe in deutscher Sprache.
- N. Chodsa: *Das betrogene Kamel. Volksmärchen, Legenden und Tierfabeln der Mongolen.* (Ost-) Berlin 1964 (eine Übersetzung aus dem Russischen)
- Erika Taube: *Das leopardenscheckige Pferd und andere tuwinische Märchen.* (Ost-) Berlin 1977
- Erika Taube: *Tuwinische Volksmärchen.* (Ost-) Berlin 1978
- Erika Taube: *Tuwinische Lieder. Volksdichtungen aus der Westmongolei.* Leipzig/Weimar 1980. Die drei letztgenannten Titel enthalten Volksdichtungen der auf dem Territorium der Mongolei lebenden Tuwa.
- Walther Heissig: *Dschingis Khan. Ein Weltreich zu Pferde.* Köln 1981. Dieser Band enthält u.a. die „Geheime Geschichte der Mongolen“ nach der ersten deutschen Übersetzung von Erich Haenisch (2. Auflage 1948) und einen Auszug aus dem mongolischen Nationalepos von Geser-Chaan.
- Klaus Koppe: *Feuer des Zorns. Eine mongolische Spielmannsdichtung.* Leipzig/Weimar 1985. Das vielleicht letzte Heldenepos der Weltliteratur aus den 1930er Jahren, einer Zeit des Kampfes gegen die japanischen Aggressoren in der Inneren Mongolei.
- Manfred Taube: *Geheime Geschichte der Mongolen.* Leipzig/Weimar 1989. Die letzte Übersetzung des bedeutendsten Werkes der altmongolischen Literatur in deutscher Sprache.

- Waltraut Fischer: *Solombo Chaan. Mongolische Märchen*. (Ost-) Berlin 1989. Nacherzählungen mongolischer Volksmärchen für eine breite Leserschaft.
- Erika Taube: *Volksmärchen der Mongolen*. München 2004. Eine umfassende, wissenschaftlich aufbereitete Sammlung mongolischer Märchen.

*Veröffentlichungen aus der modernen mongolischen Literatur in deutscher Sprache*  
*Erzählungsbände und Romane*

- Renate Bauwe (Hrsg.): *Erkundungen. 20 mongolische Erzählungen*. (Ost-) Berlin 1976. Der erste in deutscher Sprache herausgegebene Prosaband aus der modernen mongolischen Literatur mit Erzählungen von 1929 bis 1972. In ihm sind auch alle bedeutenden mongolischen Erzähler der ersten beiden Generationen nach 1921 vertreten.
- Tschadraawalyn Lodoidamba: *Der durchsichtige Tamir*. (Ost-) Berlin 1978. Dieser umfangreiche Roman gibt ein umfassendes Gesellschaftsbild der Mongolei von 1914 bis zum Beginn der 1930er Jahre. Leider eine Übersetzung aus dem Russischen, fehlendes Personenverzeichnis.
- Sengiin Erdene: *Sonnenkraniche (Erzählungen)*. (Ost-) Berlin 1979 (Übersetzung: Renate Bauwe). Der erste Erzählungsband des meistübersetzten mongolischen Prosaautors in deutscher Sprache.
- Galsan Tschinag: *Eine tuwinische Geschichte*. (Erzählungen), (Ost-) Berlin 1981. Die erste Buchveröffentlichung des deutschsprachigen Autors aus der Mongolei.
- Lodongijn Tüdew: *Bekanntschaft mit der Welt*. (episodische Prosa), (Ost-) Berlin 1982. (Übersetzung: Galsan Tschinag) Autobiographische Erinnerungen, geschrieben für Kinder und Erwachsene.
- Sengiin Erdene: *Herdenstaub*. (Erzählungen), Ulan Bator 1983 (Übersetzung: Galsan Tschinag)
- Sonomyn Lotschin: *Die Farbe der Seele*. (Ost-) Berlin 1983 (Übersetzung: Renate Bauwe). Dieser Roman erzählt vom spannungsreichen Leben von Bergarbeitern zweier Generationen. In ihm werden erstmals in der mongolischen Literatur auch die Auswirkungen der Stalinistischen Repressalien am Schicksal Einzelner gestaltet.
- Schagdardshawyn Nazagdordsh: *Mandchai die Kluge*. (Ost-) Berlin 1988. (Übersetzung: Renate Bauwe). Der Roman führt in das 15. Jahrhundert, in eine Zeit, in der die Nachkommen Tschinggis Chaans ihre letzten erfolgreichen Versuche unternahmen, das Stammland der Mongolen zusammenzuhalten.
- Von Galsan Tschinag erschienen nach 1992 über dreißig Erzählungs-, Gedicht- und Essaybände sowie Romane, mit denen er als deutschsprachiger Autor weithin bekannt wurde.
- Sengiin Erdene: "Die Frau des Jägers, Das Ende des Serüün-Tempels" Übersetzt

und herausgegeben von Renate Bauwe. Verlag: Books on Demand ISBN 978-3-8370-3844-6, 132 Seiten 1. Aufl. April 2009

## *Хавсралт 2*

- **Der siebzehnte Tag**, A1 Verlag München 1992, Zwei Erzählungen, die von der Naturverbundenheit der Menschen zeugen
- **Das Ende des Liedes**, Unionsverlag Zürich, Eine nomadische Liebesgeschichte. Für dieses Werk erhielt der Autor 1995 den Puchheimer Leserpreis
- **Der blaue Himmel**, Suhrkamp, Frankfurt 1994 /NA TaschenbuchAutobiografischer Roman, der im Hochaltai, im äußersten Westen der Mongolei, in der Heimat der Tuwa-Nomaden spielt
- **Mein Altai**, A1 Verlag München 2005, In diesem Band sind seine bisher im A1 Verlag erschienenen großen Erzählungen versammelt (Eine tuwinische Geschichte, Das Ende des Liedes, Bisen, Shanna, Dojnaa, Ildeng, Die Karawane u.a.
- **Zwanzig und ein Tag**, Suhrkamp, Frankfurt 1995 / NA Taschenbuch, Ein Roman von den Sonnen- und Schattenseiten des Nomadenlebens, einzelner Schicksale, der Verbundenheit mit dem Himmel und der Erde vor der großartigen Kulisse des Hochaltai. Der Autor versucht, das kleine Hirtenvolk der Tuwa dem Vergessen der Menschheitsgeschichte zu entreißen und ihm ein Denkmal zu setzen
- **Alle Pfade um deine Jurte**, Gedichte, Verlag Im Waldgut, CH-Frauenfeld 1995, Der erste Lyrikband des Autors in deutscher Sprache, der vor allem Liebesgedichte umfasst und in der vierten Auflage vorliegt.
- **Nimmer werde ich dich zähmen können**, Gedichte, Verlag Im Waldgut, CH-Frauenfeld 1996, Liebes- und Steppengedichte
- **Die Karawane**, Unionsverlag Zürich, Galsan Tschinag als Stammesoberhaupt der Tuwa führt sein über die Mongolei verstreutes Volk mit einer Kamelkarawane 2000 km weit zu den alten Weide- und Jagdgebieten im Hohen Altai zurück.
- **Im Land der zornigen Winde**, mit der Ethnologin Dr. Amélie Schenk, Atelier Bodoni CH-Frauenfeld/Unionsverlag Zürich, Das Buch ist eine Liebeserklärung an das Nomadenleben in der Mongolei, ein Lesebuch mit Anekdoten aus der Studentenzeit des Autors in Leipzig, eine Gegenüberstellung der Lebensweisen Ost-West, Aphorismen und Geschichten, vor allem aber die Inventarisierung der Sitten und Gebräuche eines kleinen, vom Aussterben bedrohten Volkes.
- **Wolkenhunde**, Gedichte aus der Steppe, Verlag Im Waldgut, CH-Frauenfeld 1998

- **Die graue Erde**, Insel-Verlag Frankfurt 1999 /NA Taschenbuch, Der zweite Teil der Trilogie Der blaue Himmel, Die graue Erde, Der weiße Berg, Autobiografischer Roman, der vom Schamanentum in der Zeit des Kommunismus handelt
- **Der Wolf und die Hündin**, Unionsverlag Zürich 1999, Packende Liebesgeschichte und wirklichkeitsnahe Parabel zu den Menschen, der Natur und dem großen Überlebenskampf, der tragisch im Tod endet.
- **Der weiße Berg**, Insel-Verlag Frankfurt 2000 /NA Taschenbuch, Der dritte Teil der Trilogie Der blaue Himmel, Die graue Erde, Der weiße Berg, Eindrucksvoller autobiografischer Roman vom Erwachsenwerden eines Nomadenjungen, der zwischen Tradition und moderner sozialistischer Erziehung steht
- **Sonnenrote Orakelsteine**, Verlag Im Waldgut, CH-Frauenfeld, 2000, Schamanengesänge
- **Dojnaa**, Erzählung, A1 Verlag München 2001 / Unionsverlag Zürich, Psychogramm einer Ehe in den Weiten des mongolischen Hochlandes
- **Tau und Gras**, Unionsverlag Zürich 2002, Geschichten aus Tschinags Kindheit
- **Der Steinmensch von Ak-Hem**, Gedichte, Verlag Im Waldgut, CH-Frauenfeld, 2002, Neue Gedichte aus dem Grasland
- **Das geraubte Kind**, Insel-Verlag Frankfurt, 2004, Historischer Roman nach einer Legende aus dem 18. Jahrhundert. Der Autor schildert den Kampf der Nomaden um Selbstbestimmung und Unabhängigkeit.
- **Jenseits des Schweigens**, Gedichte, Atelier Bodoni (Verlag Im Waldgut), CH-Frauenfeld, 2006
- **Das zaubermächtige Goldplättchen**, Märchen aus der Gegenwart, Atelier Bodoni (Verlag im Waldgut), CH- Frauenfeld 2006
- **Auf der großen blauen Straße**, Erzählungen und Erinnerungen, Unionsverlag 2007
- **Die neun Träume des Dschingis Khan**, Roman, Insel-Verlag Frankfurt/M, 2007, Ein Weltherrscher blickt am Ende seines Lebens zurück auf Krieg, Verrat, Mord aber auch auf Liebe und Freundschaft
- **Liebesgedichte**, Insel-Verlag 2007
- **Das Menschenwild**, Erzählung, Insel-Verlag März 2008
- **Die Rückkehr**, Roman meines Lebens, Insel-Verlag 2008, Autobiographischer Roman. Erinnerungen an bedeutsame Stationen seines Lebens und Gedanken zu traditionellem Nomadenleben und Moderne.
- **Der singende Fels**, Unionsverlag 2009, Schamanische Heilweisen und philosophische Gedankengänge spielen ineinander. Galsan Tschinag in Zusammenarbeit mit Prof. Kornwachs und Maria Kaluza
- **Das andere Dasein**, Inselverlag 2011, Eine Liebesgeschichte zwischen einem

jungen Mongolen und einer ungarischen Studentin, die auf tragische Weise getrennt werden, aber in veränderter Gestalt doch noch ihr Glück finden.

- **In der Mitte ein Feuer**, 2012, Am 4. März 2012 mit Erfolg im Fernsehen ausgestrahlt, wurden die Fotos, die der Fotograf Gernot Gleiss im Zusammenhang mit dem Film gemacht hat, auf der Leipziger Buchmesse als Buch vorgestellt. Das Buch mit dem Titel "In der Mitte ein Feuer", das sehr schöne Fotos der Tuwa-Nomaden enthält, ist ganz normal über den Buchhandel für 35,00 EUR zu bestellen, oder über [bestellabteilung@heyn.at](mailto:bestellabteilung@heyn.at). Das Buch enthält auch eine DVD mit dem Film.
- **Gold und Staub**, Unionsverlag 2012, Ein Roman über das Uralte, Unglaubliche inmitten von Profitgier und Umweltzerstörung. Vor 50 Jahren begegnete der Tuwa-Mongole Galsan Tschinag zum ersten Mal der deutschen Sprache. Inzwischen ist er zu einem der sprachmächtigsten Autoren der deutschen Literatur geworden. In diesem funkelnden, ebenso heiteren wie nachdenklichen Roman führt er uns in den innersten Kreis seines Lebens in der mongolischen Steppe. Ein Jahrhundertgedanke hat sich in seinem Hirn festgesetzt: Mit einer Million Bäume will er die Steppe begrünen. Der erste Schritt: Der öde, zerfallene Friedhof der Ahnen soll wieder hergerichtet werden. Doch dabei tun sich zahlreiche Hindernisse auf. Die Stammesleute fürchten die Geister der Toten, es fehlt an Geld, Material und Durchhaltewillen. Kann er sich auf seine Schamanenschwester verlassen? Da taucht in der Jurte des Stammesführers eine rätselhafte, blonde, berückend schöne Kasachin auf. Ihre Klugheit und Leidenschaft lässt ihn vergessen, dass sie ein eigenes, bedrohliches Ziel verfolgt.
- **Die Kraft der Schamanen**, Unionsverlag, Juni 2013, In dieser Anthologie berichten die drei großen Autoren der asiatischen Steppen und Berge von Schamaninnen und Schamanen, die sie prägten. Sie zeigen Schamanen bei der Arbeit und erzählen von einer großen Tradition, die bis heute fortwirkt.
- **Der Mann, die Frau, das Schaf, das Kind**, Roman Unionsverlag Zürich 2013, Ein Mann, eine Frau, ein Schaf - eine Begegnung nicht auf dem Land, sondern im Hausflur eines Hochhauses. Das Schaf ist am falschen Ort, aber sind es nicht vielleicht auch der Mann und die Frau?, Gier, Neid, Gewalt, alles was Menschen sich antun können, haben sie erfahren. Nun werden sie einander Zuhörer und Fürsorger.
- **Steppenwind Weltenwind, Gedichte**, 2013, Verlag Im Waldgut-CH, Galsan Tschinag sucht stärker als in den bisherigen Texten nach Ursprüngen: Der Wind als Leben bewegendes Element, das Wasser als Antrieb der Natur, des Menschen ...
- **Ohne die Tat ist alles nur Geplapper...**, Aurum Verlag Bielefeld 2015 Bildband, Text von Galsan Tschinag – Fotos und Interviewfragen von Andreas

Burhorn. Dieses Buch ist ein Spiegel für uns „Westler“. Mit diesem Spiegel eröffnet uns Galsan Tschinag neue Möglichkeiten, das eigene Leben reicher zu machen: mit Liebe, Respekt, Mut, Achtsamkeit und Humor.

### Номзүй

- [https://mn.wikipedia.org/wiki/Санжаадоржийн\\_Молор-Эрдэнэ](https://mn.wikipedia.org/wiki/Санжаадоржийн_Молор-Эрдэнэ)
- Монголын нэрт орчуулагчид, 28-р тал, Мөнхтэнгэр дэлхийн эв нэгдлийн холбоо, УБ, 2005 он
- Герман уран зохиолыг монгол хэл рүү орчуулах уламжлалаас, эрдэм шинжилгээний илтгэл, МУИС, ГХСС, Багш нарын ЭШБХ, УБ, 2007 он
- Geschichten-Үгүүллэгүүд, 6-р тал, БИТ ПРЕСС ХХК, 2010 он
- Gedichte-Шүлгүүд, 5-р тал, БИТ ПРЕСС ХХК, 2009 он
- Ариун Жадамбын, Герман-монгол хэлний байц гишүүн өгүүлбэртэй УНӨ-ийн зэрэгцүүлсэн судалгаа, дисс., 136-167 тал, УБ, 2004 он

### Abstract

The translation of “Goldbug” by Natsagdorj Dashdorj in 1930 is considered the first translation from German to Mongolian language. Most of the translations done from socialist times to democratic periods until 1990 were ideological and works of socialist authors of the DRG. Nowadays, other works such as socio-political, science and technological, philosophical, have been translated.

Researchers like Erich Haenisch, Bernhard Julg, Walther Heissig, Erika Taube, Manfred Taube, Klaus Koppe, Barkmann, Udo.B., Renate Bauwetranslated classical and modern books and my this in Mongolian-German language. Recent translation from German-Mongolian works are fewer compared to the previous works.